БНАСАУ-ын эрх баригчид дэлхийн хамтын нийгэмлэгийн уриаг хvлээн авч, Солонгосын хойгийг цэрэгжилтгvй бvс болгох асуудлаархи хэлэлцээнд орно гэдэгт Москва найдаж байна гэж очигдор Москвад ОХУ-ын ГХЯ-ны тэргvvн Сергей Лавров мэдэгдлээ. Энэ зорилгоор Пхеньян НYБ-ын АЗ-ийн тогтоолын шаардлагыг биелvvлэх ёстой гэж тэрээр тэмдэглэв. Орос улс зургаан талт хэлэлцээг сэргээхийн тулд бололцоотой бvхнийг хийнэ гэж Лавров амлав. ОХУ-ын ГХ-ийн сайд онгорсон оны 12-р сард БНАСАУ баллистик пуужинг хооргоснийг буруушаасан НYБ-ын АЗ-ийн тогтоолыг тайлбарлахдаа энэ асуудлаар Орос улсын vнэлгээ АЗ-ийн гишvvн бусад улсын байр сууринд нийцэж байгааг мэдэгдэв. Цэргийн сvр хvчээ зузаатгаж, Солонгосын хойгийг цэрэгжилтгvй болгох vйл ажиллагаагаа зогсооно гэж Пхеньян мон тогтоолыг батласны хариуд сvрдvvлэв.